



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 5/964

Улаанбаатар хот

Ю.Болорыг ажлаас чөлөөлж, нэг удаагийн  
буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.7, 271<sup>1</sup>.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Улаанбаатар хот дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Юнгэрийн Болорыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ю.Болорт төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 20 189 180 / хорин сая нэг зуун наян есөн мянга нэг зуун наян / төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Ю.Болорын гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Улаанбаатар хот дахь гаалийн газар /Б.Отгонсүх/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 3068